

## СОЛОНГОСЧУУДЫН СОНГОЛТ : ПАК ГЫН ХЭ

Д.Оюунцэцэг\*

Эдийн засгийн үсрэнгүй хөгжлөөрөө дэлхийн хүчирхэг гүрнүүдийн тоонд багтсан БНСУ шинэ оны өмнөхөн эмэгтэй ерөнхийлөгчтэй болсон нь дэлхий дахины анхаарлыг татсан үйл явдал болсон юм. Энэхүү илтгэлийн зорилго нь 2012 оны 12-р сарын 19-ний өдөр болж өнгөрсөн БНСУ-ын Ерөнхийлөгчийн 18 дахь удаагийн сонгуулийн үр дүн, сонгуульд ялалт байгуулсан Сэнүри намаас нэр дэвшигч Пак Гын Хэ, түүнийг сонгосон учир шалтгаан, ард түмний хүлээлт зэргийг Солонгосын болоод бусад орны өдөр тутмын сонин хэвлэл, телевизийн мэдээ мэдээллийн нэвтрүүлэг, олон нийтийн дунд явуулсан санал асуулга, гадаад дотоодын эрдэмтэн судлаачид, дипломатуудын өгсөн ярилцлага зэргийг үзэж судлан, анализ шинжилгээ хийж, дүгнэхийг зорьсон болно.

### 1. БНСУ –ын Ерөнхийлөгчийн 18 дахь удаагийн сонгууль

2012 оны 12 сарын 19–ны өдөр БНСУ-ын Ерөнхийлөгчийн 18 дахь удаагийн сонгууль орон даяар болж өндөрлөлөө. Сонгуульд өрсөлдсөн “Нэгдсэн ардчилсан нам” –ын нэр дэвшигч Мүн Жэ Ин нийт сонгогчдын 48,9 хувийн санал авсан бол “Сэнүри” намаас нэр дэвшсэн Пак Гын Хэ 15 сая 773 мянга 128 санал буюу 51,6 хувь хувийн санал авч БНСУ-ын 18 дахь удаагийн ерөнхийлөгчөөр сонгогдсон юм.<sup>1</sup>

Солонгосчууд яагаад эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалыг сонгох болов? Тэдний сонголтонд юу нөлөөлөв? Социологийн судалгаа явуулдаг мэргэжлийн томоохон байгууллага болох Галлап Кореа судалгааны хүрээлэнгээс сонгуулийн өдрийн 18.00-21.00 цагийн хооронд гар утсаар авсан санал асуулгын дүнгээс харахад санал асуулгад оролцсон, сонгуульд санал өгсөн 19-с дээш насны 1036 сонгогчийн 482 нь Пак нэр дэвшигчийг дэмжсэн байна. Пак нэр дэвшигчийг сонгосон шалтгааныг нь тодруулахад 22 хувь нь итгэж болох хүн, хэлсэн үгэндээ хүрдэг учраас, 14 хувь нь мөрийн хөтөлбөр, баримтлах бодлого нь нөлөөлсөн, 14 хувь нь анхны эмэгтэй ерөнхийлөгчийг төрүүлэхийн тулд, 12 хувь нь чадварлаг, сайн ерөнхийлөгч болж чадна гэж үзсэн учраас, 10 хувь нь харьяалагддаг улс төрийн намыг нь дэмждэг, 9 хувь нь тогтвортой, тууштай байж чадах хүн, 9 хувь нь улс орны аюулгүй байдлыг хамгаалж чадна, 8 хувь нь туршлагатай улс төрч, 6 хувь нь өрсөлдөгчийг нь дэмждэггүй учраас, 5 хувь нь Пак

\* МУИС, ОУХС-ийн багш, докторант

1. 중앙선거관리위원회 [www.nec.gk.kr](http://www.nec.gk.kr) БНСУ-ын Сонгуулийн ерөнхий хорооны цахим

Жон Хи ерөнхийлөгчийн охин учраас дэмжсэн<sup>2</sup> гэж тайлбарласан байна.

Санал асуулгын дүн, мэдээ мэдээлэл, ярилцлага зэрэг холбогдох эх сурвалжуудаас дүгнэлт хийж, сонгогчдын Пак Гын Хэ нэр дэвшигчийг сонгосон шалтгааныг дараах байдлаар жагсааж үзлээ.

1.1. Нийгмийн сэтгэлгээний өөрчлөлт буюу Эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалыг хүлээн зөвшөөрөх нь

БНСУ-ын олон нийтийн телевиз болох KBS<sup>3</sup>, MBC<sup>4</sup>, SBS<sup>5</sup> телевизүүд хамтран сонгуулийн өдөр 06.00-17.00 цагийн хооронд улс даяар ажилласан 360 сонгуулийн хэсэгт санал өгсөн 86 мянган сонгогчоос авсан судалгааны дүн<sup>6</sup>-гээс харвал судалгаанд оролцогсдын 50,1 хувь нь, түүний дотор эрэгтэйчүүдийн 49,1 хувь, эмэгтэйчүүдийн 51,1 хувь нь Пак Гын Хэгийн төлөө саналаа өгсөн байна. Үүнээс харахад Пак нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн сонгогчдын хүйсийн харьцаа төдийлэн хол зөрүүтэй байсангүй.

Саяхныг хүртэл хүйсийн эрх тэгш байдлын индексээр (GGI: Global Gender Gap Index)<sup>7</sup>, хүйсийн эрх мэдлийн хэмжүүрээр (GEM: Gender Empowerment Measure)<sup>8</sup> доогуур үзүүлэлттэй байсан БНСУ-ын хувьд нэг хоёрхон жилийн дотор эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь эрс өсөн нэмэгдэж, эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалыг нийгмийн сэтгэл зүй хэдийнээ хүлээн зөвшөөрчихлөө гэж үү?

Өнөөдөр Солонгосын нийгэмд, нийгмийн бүхий л салбарт эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь өсөн нэмэгдсээр байгааг зарим нэг статистик үзүүлэлтээс харж болно. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 84,1 буюу эрэгтэйчүүдийнхээс 6,9 жилээр урт байгаа нь хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байгаа бас нэгэн үзүүлэлт болж байна. 2012 оны 10-р сарын байдлаар БНСУ-ын хүн ам 50 сая 912,3 мянганд хүрсний дотор 25 сая 424,2 мянга нь эмэгтэйчүүд байсан нь нийт хүн амын 49,9

2. 한국갤럽 Gallup Report 2012/12/24; 제18대대통령선거, 유권자의후보선택이유는? P.2. www.gallup.co.kr Галлап Кореа судалгааны тайлан. 2012/12/24, 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгууль. Нэр дэвшигчийг сонгосон шалтгаан. Хуудас 2.

3. KBS. БНСУ-ын олон нийтийн телевиз.

4. MBC. БНСУ-ын олон нийтийн телевиз.

5. SBS. БНСУ-ын хувийн томоохон телевизүүдийн нэг.

6. <http://www.polinews.co.kr/news/article.html?no=165453>

7. Дэлхийн Эдийн Засгийн Форумас дэлхийн улс орнуудын эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм эдийн засгийн оролцоо, боловсрол эзэмшсэн байдал зэрэг 14 үзүүлэлтээр гаргадаг хүйсийн эрх тэгш байдлын индексээр БНСУ 2009 оны байдлаар 115, 2010 оны байдлаар 104, 2011 оны байдлаар 135 орноос 107-р байранд жагссан байна. [http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2009.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2009.pdf) [http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2010.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2010.pdf) [http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2011.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2011.pdf)

8. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-өөс улс орнуудын эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгмийн шийдвэр гаргах түвшин дэхь оролцоогоор үнэлэн гаргадаг хүйсийн эрхийн индексээр (Gender Empowerment Measure) БНСУ 2008 оны байдлаар 64-т, 2009 оны байдлаар 61-т бичигджээ. [http://hdr.undp.org/en/media/HDR\\_20072008\\_GEM.pdf](http://hdr.undp.org/en/media/HDR_20072008_GEM.pdf)

хувийг эзэлж байгаа юм. ( хүснэгт 1)<sup>9</sup>

Төрийн албанд ч, хувийн салбарт ч ажил хөдөлмөр, бизнес эрхлэх эмэгтэйчүүдийн тоо жилээс жилд өссөөр байгаа нь нийгмийн бүхий л салбарт эмэгтэйчүүдийн нэр хүнд байр суурь өсөж байгааг харуулж байгаа хэрэг юм. 2012 оны байдлаар засаг захиргааны байгууллагуудад ажилладаг төрийн албан хаагчдын 30,7 хувь, эмч, инженер гэх мэт нарийн мэргэжлийн ажилтнууд болоод удирдах албан тушаалтнуудын 21,6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.<sup>10</sup>(хүснэгт 2-4) Сүүлийн жилүүдэд жил бүр явагддаг хууль эрх зүйн шалгалт, төрийн албан хаагчийн шалгалт, гадаад хэргийн яамны шалгалтанд тэнцсэн эмэгтэйчүүдийн хувь хэмжээ тогтмол 45-50 хувь байна. Мөн их дээд сургуульд элсэгчдийн дотор эмэгтэй оюутны эзлэх хувь сүүлийн 3 жил тогтмол өсөж байгаа зэрэг эерэг үзүүлэлтүүдийг БНСУ-ын статистикийн ерөнхий газраас гаргажээ. Мөн дунд сургуулийн 4 багш тутмын 3 нь, шүдний эмч нарын 25 хувь, нарийн мэргэжлийн эмч нарын 22,6 хувь, уламжлалт эмчилгээний эмч нарын 16,9 хувь нь эмэгтэй хүн байгаа зэргийг дурдаж болно.<sup>11</sup>

Гэхдээ шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага, тэдний дуу хоолой сул байна. 2012 оны 19 дэх удаагийн парламентад 47 эмэгтэй гишүүн сонгогдсон нь нийт гишүүдийн дөнгөж 15,7 хувийг эзэлж байгаа юм. Энэхүү үзүүлэлтээрээ Олон Улсын Парламентын Холбооны парламентад эзлэх эмэгтэй гишүүний хувийн жагсаалтанд 87 дугаарт бичигджээ.<sup>12</sup> ( хүснэгт 5)

Ийнхүү эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилсэн, хүйсээс үл хамааран хүний мэдлэг чадварыг үнэлэх болсон, эмэгтэйчүүдийг мэдлэг мэргэжлийн хувьд хүлээн зөвшөөрөх болсон нь эмэгтэйчүүдийн нийгэм улс төрийн байр суурь өсөхөд нөлөөлж, төрийн өндөр албан тушаалд эмэгтэй хүнийг сонгох, тэдэнд боломж олгож, итгэл хүлээлгэх болсон байна.

“Мидиком” судалгааны компани 2012-11-24 нөөс 30-ны хооронд олон нийтийн цахим хуудсанд бичсэн 6861 сэтгэгдэлд анализ хийж гаргасан судалгааны үр дүнгээс харахад Пак нэр дэвшигчийн бичсэн “БНСУ-д эмэгтэйчүүдийн манлайлал хэрэгтэй” хэмээх тайлбартай санал нэгтэй байна гэж дийлэнх олонхи нь үзсэн бол “эмэгтэй ерөнхийлөгчийн засаглал”-ын талаар 79,3 хувь нь эерэг сэтгэгдэл, 18,7 хувь нь сөрөг сэтгэгдэл бичсэн байжээ.<sup>13</sup>

“Хангён глобал судалгаа” компаниас явуулсан судалгааны дүнгээс

9. <http://rcps.egov.go.kr:8081/ageStat.do?command=month>

10. [http://www.index.go.kr/egams/stts/jsp/potal/stts/PO\\_STTS\\_IdxMain.jsp?idx\\_cd=1575](http://www.index.go.kr/egams/stts/jsp/potal/stts/PO_STTS_IdxMain.jsp?idx_cd=1575)

11. [http://news.sbs.co.kr/section\\_news/news\\_read.jsp?news\\_id=N1001252110](http://news.sbs.co.kr/section_news/news_read.jsp?news_id=N1001252110)

12. [http://www.index.go.kr/egams/stts/jsp/potal/stts/PO\\_STTS\\_IdxMain.jsp?idx\\_cd=1588](http://www.index.go.kr/egams/stts/jsp/potal/stts/PO_STTS_IdxMain.jsp?idx_cd=1588)

13. <http://www.asiatoday.co.kr/news/view.asp?seq=743494>

харахад “эмэгтэй ерөнхийлөгчийн засаглал” буюу “эмэгтэй ерөнхийлөгч төрнө гэдэг өөрөө хамгийн том өөрчлөлт, улс төрийн шинэчлэл юм” гэж хэлсэн Пак Гын Хэгийн үгтэй 55,9 хувь нь санал нэгтэй байна гэжээ. Санал нэгтэй дэмжигчдийн 60,5 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Насны хувьд 20 орчим насныхны 58,9 хувь, 30 орчим насныхны 57,6 хувь нь эмэгтэй ерөнхийлөгчийг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн бол 40 наснаас эхлээд тэн хагасаас илүү хувь нь, 60-с дээш насныхны 68,6 хувь нь дэмжсэн байна.<sup>14</sup>

Дээрх тоон үзүүлэлтүүдээс харахад нийгэмд эзлэх эмэгтэйчүүдийн байр суурь өсөн нэмэгдсэнээр солонгосын нийгмийн сэтгэлгээнд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзэл харьцангуй багасаж, БНСУ эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалтай байж болно гэдгийг иргэд нь хэдийн хүлээн зөвшөөрөх болсныг харуулж байна. Ялангуяа дөчөөс дээш насныхан үүнд шинэлэг сэтгэлгээгээр хандах болсон нь энэ удаагийн сонгуульд эмэгтэй нэр дэвшигч ялж, БНСУ эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалтай болоход багагүй нөлөөлсөн юм.

## 1.2. Сонгогчдын нас

БНСУ-ын 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгуульд сонгуулийн насны эрэгтэй сонгогчдын 74,8 хувь, эмэгтэй сонгогчдын 76,4 хувь нь санал өгсөн бол сонгуульд оролцохоор бүртгэгдсэн 20-30 насныхны 68,5 хувь, 30-40 насныхны 70 хувь, 40-50 насныхны 75,6 хувь, 50-60 насныхны 82 хувь, 60-80 насныхны 80,9 хувь нь саналаа өгсөн байна.<sup>15</sup> Харин сонгуулийн өдөр явагдсан 86 мянган сонгогчоос авсан санал асуулгын дүнгээр 20 орчим насныхны 33,7 хувь нь, 30 орчим насныхны 33,1 хувь, 40 орчим насныхны 44,1 хувь, 50 орчим насныхны 62,5 хувь, 60-аас дээш насныхны 72,3 хувь нь Пак нэр дэвшигчийг дэмжсэн байна.<sup>16</sup> Эндээс сонгуульд 50-иас дээш насныхан идэвхтэй оролцож, тэдний дийлэнх хувь нь Пак нэр дэвшигчийг дэмжсэн дүр зураг харагдаж байгаа юм.

Эдийн засаг, нийгмийн олон шалтгааны улмаас жил ирэх тусам төрөлт багасч, хүмүүсийн дундаж наслалт уртасч, Солонгосын нийгэмд хөгшрөлт явагдаж эхлээд байгаа билээ. 10 жилийн өмнө БНСУ-д 20-30 насны 16 сая 900 мянга, 50-иас дээш насны 10 сая 240 мянган сонгогч байсан бол 2012 оны байдлаар 20-30 насны сонгогчдын тоо 1 сая 410 мянгаар буурч, 50-иас дээш насны сонгогчдын тоо 6 саяар нэмэгдсэн байна.<sup>17</sup>

60-иас дээш насны сонгогчид Пак нэр дэвшигчийн эцэг Пак Жон Хигийн удирдлага дор эх орны их бүтээн байгуулалтыг гардан босгогчид, өнөөдрийн Солонгосын хөгжил цэцэглэлтийн эх үндсийг тавьсан

14. <http://www.hankyung.com/news/app/newsview.php?aid=2012111101801>

15. <http://m.nec.go.kr/front/board/detail.nec?bmSeq=8&bcSeq=1168>

16. <http://www.polinews.co.kr/news/article.html?no=165453>

17. 2012/12/22 매일경제 A28. <매경이 만난 사람>. Өдөр тутмын эдийн засаг сонин 2012 -12- 22 өдрийн дугаар. A28 тал.

хүмүүс билээ. Тэд түүний эцгийг хайрлан хүндэтгэдэг, охиных нь туулж ирсэн амьдралын замналыг мэддэг. Тиймээс ч тэд Пак нэр дэвшигчийн улс төрчийн амьдралын туршлага нь улс орныг удирдан жолоодоход хангалттай гэж үзсэнтэй холбоотой юм.

### 1.3. Солонгосын өнөөгийн улс төрийн байдал

Солонгосын хойгийн асуудал тухайлбал Өмнөд, Умард Солонгосын харилцаа нь бүс нутгийн төдийгүй дэлхий дахины анхаарлын төвд байдаг билээ. Үргэлжийн тогтворгүй, үе үе хурцадмал байдлыг үүсгэж байдаг, цаашид байдал яаж эргэх нь тодорхойгүй байгаа энэ ноцтой асуудал өмнөд Солонгосын иргэдийн сэтгэл санааг үргэлжид зовоосоор ирсэн. Ким Дэ Жүн, Ну Мү Хён ерөнхийлөгчийн үед харьцангуй тайван, энхийн байдалтай байсан харилцаанд И Мён Пак ерөнхийлөгчийн Засгийн Газар хатуухан гараар хандаж байсан нь иргэдийн дэмжлэгийг тэр бүр хүлээхгүй байсан нь тодорхой юм. Пак нэр дэвшигч 1974-1979 оны хооронд тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж байсан, олон улсын тавцанд нэр хүндтэй улс төрч юм. Тэрээр 2002 онд улс төрч, нийгмийн зүтгэлтний хувиар БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ильтэй нүүр тулан уулзаж байсан нь хоёр Солонгосын харилцаанд хэрхэн хандах талаарх өөрийн ойлголтоо бататган, хөтөлбөрөө боловсруулахад нь чухал түлхэц болсон юм. Пак нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө харилцан ойлголцол, итгэлцлийг бататгах замаар Өмнөд болон Умард Солонгосын харилцааг сайжруулах, хөгжүүлэх, цаашлаад хоёр Солонгосын эв нэгдлийн үндэс суурийг тавих, Зүүн Хойд Азийн бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг идэвхтэй явуулснаар Умардын цөмийн аюулыг зайлуулж, Солонгосын хойгт энхтайвныг тогтоох зорилго бүхий “Солонгосын хойгийн итгэлцлийн үйл явц” бодлогоо гаргаж тавьсан нь ард иргэдийн дэмжлэгийг хүлээсэн гэж болно. Айдас түгшүүр, сэтгэл зовоосон энэ асуудлаас авахуулаад газар нутгийн маргаан гэх мэт улс орны аюулгүй байдалд халдсан аливаа асуудалд Пак нэр дэвшигчийн туршлагатай улс төрчийн холч ухаан, эмэгтэй хүний тайван уужуу сэтгэл, аливаад нухацтай хандах байдал нөлөөлж чадна гэж сонгогчдын 9 хувь нь үзсэн байна.<sup>18</sup>

### 1.4. Солонгосын эдийн засгийн өнөөгийн байдал

И Мён Пак ерөнхийлөгчийн Засгийн Газрын үед БНСУ-ын эдийн засаг өсөж, улс орны гадаад нэр хүнд дээшилж, дэлхийн хүчирхэг улсууд, донор орнуудын эгнээнд багтаад байгаа билээ. Хүн амын тоо 50 саяыг давж, ДНБ-ний хэмжээ 1 629 900 сая ам доллар хүрч дэлхийд 12-р байранд, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр 31 714 ам долларт хүрч

18. 한국갤럽 Gallup Report 2012/12/24; 제18대대통령선거, 유권자의 후보선택이유는? P.2. www.gallup.co.kr Галлап Кореа судалгааны тайлан. 2012/12/24, 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгууль. Нэр дэвшигчийг сонгосон шалтгаан. Хуудас 2.

хөгжингүй эдийн засагтай орны үзүүлэлтэнд хүрч чадсан.<sup>19</sup> Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт, энэ бүх ололт амжилт нийгмийн цөөн давхарга болох томоохон компани, корпорацийн эзэд, жэболуудын<sup>20</sup> амьдралд л мэдрэгдэхээс ард түмний амьдрал төдийлэн өөрчлөгдөөгүй, нийгмийн дундаж давхаргынхны амьдрал харин ч дордож, баян ядуугийн ялгаа ихэссэн гэж иргэд үзэж байгаа аж.

Эдийн засгийн өсөлтийн үр ашгийг хүртэж чадсан, өөрөөр хэлбэл амьдрал ахуй нь дээшилсэн ихэнх иргэдийн хувьд тэдний нийгмийн оролцоо дээшилж, улс төр, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нь сайн сайхан амьдралаа бүтээн босгох боломжийг өөрсдөө бий болгож байна хэмээн ойлгож, улс төр нийгмийн амьдралд бодит үнэлэлт дүгнэлт, зөв, оновчтой сонголт хийх болсон. Харин амьдрал дордож, ядуу зүдүү байгаа нь улс орны явуулж буй бодлого, нийгмийн буруугаас хэмээн үзэж, төрөөс халамж, дэмжлэг тэтгэлэг шаардах иргэдийн тоо эрс нэмэгдсэн нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр зарим нэг амлалтуудад итгэн сонголтоо хийхэд хүргэсэн талтай гэж судлаачид үзжээ. Ард иргэдийн 51,5 хувь нь өөрсдийгөө дундаас дээд давхаргынх гэж үзсэн бол 45,5 хувь нь дунд болон түүнээс доош давхаргынх гэж үздэг<sup>21</sup> судалгаа гарсан байна.

Үнэндээ Пак нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт нийгмийн дунд давхаргынхны амьдрал ахуйг дэмжиж тэтгэх, эдийн засгийн ардчилал буюу орлогын хэт ялгааг багасгах, бага дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн нуруун дээрх орон сууцны зээл, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үнэ төлбөрийн дарамтыг багасгахад чиглэсэн бодлогууд түлхүү тусгагдсан нь нийгмийн дунд давхаргынханд горьдлого найдлага, итгэл үнэмшил төрүүлсэн нь дамжиггүй. Түүний мөрийн хөтөлбөр, баримтлах бодлогыг дэмжиж сонгосон сонгогчдын хамгийн ихээр дэмжсэн нь ард иргэдийн амьдралыг тогтвортой байлгах (8%), дунд түвшингийн иргэдийн амжиргааг дээшлүүлэх (6%), сургалтын төлбөрийн тал хувийг хөнгөлөх (4%), нийгмийн халамжийг нэмэгдүүлэх (4%), улс орны аюулгүй байдлыг хамгаалах (4%) зэрэг мөрийн хөтөлбөрүүд байжээ.<sup>22</sup>

МВС телевизийн захиалгаар Каллап Кореа судалгааны хүрээлэнгээс 2012-12 -29 ний өдөр 19-с дээш насны 1052 иргэний дунд явуулсан санал асуулгаар нийт оролцогчдын 54,5 хувь нь И Мён Пакийн засгийн газар муу ажилласан гэж үзээд үйл ажиллагаанд нь сэтгэл ханамжгүй байгаагаа

19. [http://en.wikipedia.org/wiki/South\\_Korea#Economy](http://en.wikipedia.org/wiki/South_Korea#Economy)

20. Жэбол (재벌) гэдэг нь нэг гэр бүлийн гишүүдийн мэдэлд байдаг, асар их хэмжээний хөрөнгө бүхий корпораци. Тухайн корпорацийн удирдах эрх бүхий гишүүн гэсэн ойлголт.

21. 한국갤럽 Gallup Report 2012/12/24; 제18대대통령선거, 유권자의후보선택이유는? P.2. [www.gallup.co.kr](http://www.gallup.co.kr) Галлап Кореа судалгааны тайлан. 2012/12/24, 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгууль. Нэр дэвшигчийг сонгосон шалтгаан. Хуудас 2.

22. [http://en.wikipedia.org/wiki/South\\_Korea#Economy](http://en.wikipedia.org/wiki/South_Korea#Economy)



илэрхийлжээ. Санал асуулгад оролцогсдын дөнгөж 24,1 хувь нь сайн ажилласан<sup>23</sup> гэж дүгнэсэн байна. Иргэдийн сонголтонд өнөөгийн засгийн газрын үйл ажиллагаа хийгээд ард иргэдийн амьдрал ахуй, амьжиргаа зэрэг эдийн засгийн байдалтай холбоотой хүчин зүйлүүд багагүй нөлөөлсөн юм.

### **1.5. Пак Гөн Хэгийн хувь хүнийх нь хувьд сонгосон шалтгаан.**

#### **Зарчимч, итгэлтэй, хэлсэн үгэндээ эзэн болдог чанар**

Энэ бол түүний улс төрчийн бодит дүр төрх. Тэрээр улс төрийн амьдралд хөл тавьснаасаа хойших энэ олон жил ард түмэнд үүнийгээ харуулж чаджээ. Сэжун хотыг хамгаалж үлдсэн явдал, намын даргын хувьд ард түмний өмнө уулчлалт гуйсан явдал зэрэг нь түүнд итгэх итгэлийг ард иргэдэд төрүүлжээ. Улс төрч хүн ард түмний өмнө худал хэлэх ёсгүй, хэлсэн үгээ биелүүлэх ёстой гэж үздэг нь түүний баримтладаг үндсэн зарчим юм. Тэрээр өдөр тутмынхаа бүх зүйлийг хэнд юу гэж хэлж, юу гэж амалснаа, тэр амлалтаа хэрхэн биелүүлэхээ нэг бүрчлэн тэмдэглэлийн дэвтэртээ бичиж авдаг. Парламентын сонгууль, орон нутгийн сонгуулийн үеэр өгсөн амлалт, ард иргэдтэй уулзсан уулзалтын үеэрээ өгсөн амлалт зэргээ бүгдийг нь бичээд хэрхэн биелэгдсэн, биелэгдэж амжаагүй бол ямар шатанд яваа зэргийг нэгбүрчлэн тэмдэглэсэн “Ард түмэнд өгсөн амлалтын цагаан ном” хэмээх номыг 2006 онд хэвлүүлэн гаргасан нь хэлсэн үгэндээ эзэн болдог түүний чанарыг бэлхнээ харуулна.

Тэрээр Ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараа ард түмэндээ хандаж үг хэлэхдээ “Ард түмний ерөнхийлөгч, амалсандаа хүрдэг ерөнхийлөгч, нэгдсэн улсын ерөнхийлөгч болно гэсэн амлалтаа заавал биелүүлнэ. Та бүхний итгэлийг зүрх сэтгэлдээ хадгалж, ард түмэндээ аз жаргалтай эрин үеийн үүд хаалгыг нээж өгөх болно”<sup>24</sup> гэжээ.

#### **Туршлагатай улс төрчийн амьдралын туршлага, туулж ирсэн замнал:**

1952 онд БНСУ-ын Тэгү хотод төрж өссөн тэрээр эцэг Пак Жон Хиг ерөнхийлөгч болсны дараагаас буюу 11 настайгаасаа эхлэн Хөх ордонд бага насаа өнгөрүүлжээ. 22 насандаа эхээсээ хагацсан тэрээр Францад сурч байснаа орхин эцгийнхээ дэргэд ирж, 5 жилийн турш улсын “Тэргүүн хатагтай”-н үүргийг гүйцэтгэж байсан юм.

1980 оноос эхлэн улс төрийн амьдралд хөл тавьж, 1998 оноос хойш нийт 5 удаа БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүнээр сонгогдож байжээ. Тэрээр сонгуулийн хууль бус мөнгөний хэрэг, хээл хахууль, авилгалын хэрэг, хуурамч сонгууль гэх мэт удаагийн ноцтой асуудлаас болж нэр хүнд нь юу ч үгүй унаж, дахин сэхэхийн аргагүй хүнд байдалд орсон Ханнара намын дарга, намын онцгой байдлын хорооны даргаар ажиллаж, эгзэгтэй

23. Жэбол (재벌) гэдэг нь нэг гэр бүлийн гишүүдийн мэдэлд байдаг, асар их хэмжээний хөрөнгө бүхий корпораци. Тухайн корпорацийн удирдах эрх бүхий гишүүн гэсэн ойлголт.

24. [http://www.ytn.co.kr/\\_ln/0101\\_201212200108200554](http://www.ytn.co.kr/_ln/0101_201212200108200554)

үе болгонд аврагчийн үүргийг амжилттай гүйцэтгэж байсан алсын хараатай, туршлагатай, шалгарсан улс төрч юм. Намын Онцгой Байдлын Хорооны даргаар ажиллаж байхдаа намын нэрийг Сэнүри нам болгон өөрчилж, намын дотор зоригтой шинэчлэл хийснээр дараагийн сонгуульд эрх баригч намын байр суурийг хадгалж чадсан юм.

Улс төрийн амьдралд хөл тавьснаас хойших түүний амьдралын туршлага, туулж ирсэн замнал, зовлон бэрхшээлийг даван туулж байсан сэтгэлийн хат, зоригтой дайчин чанар нь ард иргэдэд нь үлгэр дууриал болдог байна.

**Аливаад ул суурьтай, уужуу тайван ханддаг, алтан дунджыг олж чаддаг чанар ба тогтвортой аюулгүй байдлыг бүрдүүлэгч:**

Улс орны аюулгүй байдалд ноцтой асуудал тулгарч, хурцадмал байдал үүсэх үед Пак нэр дэвшигчийн аливаад ул суурьтай, уужуу тайвуу ханддаг, эв эеийг хичээдэг зөөлөн зан чанар нөлөөлж улс орны тогтвортой, аюулгүй байдлыг бүрдүүлж өгнө гэж судлаачид, ард иргэд үзжээ. Ард түмний амьдрал доройтож буй энэ үед амьдралын туршлагаараа, ард түмнийхээ амьдралын зовлон жаргалыг тал бүрээс нь ойлгож, улс гэрийг аваад явах эмэгтэй хүний нарийн мяндсан ухаан, аливаад алтан дундажыг барьж ханддаг ухаалаг чанар түүнд бий гэж улс төрчид дүгнэжээ.

**Эх оронтойгоо гэрлэсэн ганц бие эмэгтэй:**

Тэрээр гэрлэж байгаагүй, үр хүүхэдгүй ганц бие эмэгтэй.

Солонгосын нийгэмд өндөр албан тушаалтнууд албан тушаалаа ашиглан, хөрөнгө мөнгө завших, хээл хахуулийн хэрэгт орооцолдох нь байнгын үзэгдэл болоод байгаа билээ. Ерөнхийлөгчийн албаа дуусгаад прокурорт шалгагдах нь ёс болсон мэт энэ улсад ганц бие эмэгтэй ерөнхийлөгч гарсан нь дээрх хууль бус үйлдэл гарахгүй байх магадлал илүү өндөр байх болно гэсэн итгэлийг ард иргэдэд төрүүлсэн байна. 2012-12-16 нд болсон телевизийн халз мэтгэлцээний үеэр өөрийгөө “Би бол БНСУ-тай гэрлэсэн эмэгтэй” хэмээгээд эх орныхоо төлөө сэтгэл зүрх, хүч чадал бүхнээ зориулна”<sup>25</sup> хэлжээ.

**Пак Жон Хи Ерөнхийлөгчийн охины нэр хүнд:**

Ерөнхийлөгч Пак Жон Хи, хэдийгээр дарангуйлагч хэмээгддэг байсан ч өнөөгийн Солонгосын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн эх суурийг тавьсан бөгөөд түүний хатуу зарчим, удирдлагын дор энэ улс хөгжлийн замдаа орсныг хүлээн зөвшөөрөх иргэд ялангуяа тухайн үед амьдарч байсан жараас дээш насны иргэдийн олонхи нь Пак нэр дэвшигчийг дэмжсэн байдаг. Үнэндээ түүний эцгийн хатуу зарчимч зан чанар, хүн таньж чаддаг, ухаалаг зан байдал нь охинд өвлөгдснийг бүгд хүлээн зөвшөөрдөг байна.

25. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201306300849313904\\_001](http://www.ytn.co.kr/_ln/0104_201306300849313904_001)



Эцэгтэй нь, мөн тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж байх үед өөртэй нь уулзаж ярилцаж байсан гадаадын улс төрчид, төр нийгмийн зүтгэлтнүүдийн дунд тэр нэр хүндтэй ухаалаг солонгос бүсгүй гэж тооцогддог. 2002 онд БНАСАУ-ын удирдагч Ким Жон Иль, 2005 онд БНХАУ-ын дарга Ху Жинтао, Японы ерөнхий сайд Койзуми, АНУ-ын БХЯамны сайд Дональд Рамсфельд, 2006 онд ХБНГУ-ын Канцлер Ангела Меркель, 2007 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Кондализа Райс гээд олон орны төрийн тэргүүн, төр нийгмийн зүтгэлтнүүд түүнийг хүндэтгэн хүлээн авч уулзан, санал бодлоо солилцож байсан нь Пак Гын Хэ ерөнхийлөгчийн олон улсын нэр хүндийг бэлхнээ харуулна. Сонирхуулж дурдахад Ким Жон Иль дарга түүнийг Умард Солонгост айлчлахад тусгайлан онгоц илгээж байсан хэмээн тэрээр дурдатгалдаа бичсэн байдаг.

Улс орнуудын харилцаа хүмүүсийн харилцаан дээр тулгуурладаг. Дэлхийн улс орнуудын олон сайхан хүмүүстэй тогтоосон найрсаг харилцаа нь улс орны харилцааг ч өргөжүүлэн хөгжүүлэх нь дамжиггүй юм. БНСУ-ын 18 дахь удаагийн Ерөнхийлөгчид сонгогдсон Пак Гын Хи 2013 оны 2 сарын 25-нд тангараг өргөх ёслолоо хийх бөгөөд уг ёслолд нийт 60 мянга орчим хүн уригджээ. Анхны эмэгтэй ерөнхийлөгч, эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалаас БНСУ-ын иргэд төдийгүй дэлхийн бусад улс орны удирдагчид олон зүйлийг харж хүлээж байна.

## **2. Ард иргэдийн хүлээлт ба гадаад ертөнц**

Түүний сонгосон иргэд хамгийн ихээр юуг хүлээж байна вэ?

Шинэ оны босгон дээр БНСУ-ын МВС телевизээс явуулсан санал асуулгын дүнгээс харахад 10 хүний 8 нь түүнийг ирэх 5 жилд үүрэгт ажлаа сайн гүйцэтгэнэ гэж итгэж байна гэжээ. Түүнийг сонгосон нийт сонгогчдын 96 хувь Мүн Жэ Ин нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн сонгогчдын талас илүү хувь нь ийн хариулсан байна. Насны хувьд харахад 50-иас дээш насныхны 90-ээс илүү хувь нь эерэг хариулт өгчээ.<sup>26</sup>

Дараагийн засгийн газрын нэн даруй хийх шаардлагатай ажил бол эдийн засгийг сэргээх, бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой барих зэрэг эдийн засгийн яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй гэжээ. Нийгмийн халамжийн бодлого, нийгмийн аюулгүй байдлын сүлжээг бататгах, улс төр, нийгмийн өөрчлөлт шинэчлэлийг хоёрдугаарт тавьсан байна. Иргэдийн 2/3 нь түүнийг эдийн засгийг аварч чадна гэсэн бол 10 иргэний 6 нь хоёр Солонгосын асуудлыг нааштайгаар шийдэж улс үндэстнийг нэгтгэж чадна гэж итгэж байгаагаа илэрхийлжээ.<sup>27</sup>

26. [http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551\\_5968.html](http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551_5968.html)

27. <http://news.nayer.com/main/read.nhn?mid=smn&sid1=100&oid=214&aid=0000226175&dateti me=20130101213427 26175>

Сэнүри намын дарга Хуан Ү Ё “Хуучныг баримтлах өнгө аястай эрх баригч намаас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн эмэгтэй нэр дэвшигч ялалт байгуулна гэдэг энэ орны улс төрд гарч буй эрс өөрчлөлт юм” гээд “БНСУ эмэгтэй ерөнхийлөгчтэй болсон нь Ази, цаашлаад дэлхий дахинд асар том нөлөө үзүүлнэ”<sup>28</sup> гэж бодож байна гэжээ. БНСУ-ын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Ким Жон Сүг “Олон улсын статистик судалгаагаар манай улсын эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь доогуур үзүүлэлттэй гардаг. Пак ерөнхийлөгч энэ улсад эмэгтэйчүүдийн эрх, байр суурь дээшилж байгаа гэсэн дохиог олон улсын нийгэмлэгт илгээж байна. Эмэгтэй хүний өөрийн гэсэн манлайллаар төрийн хэргийг явуулна гэдэг итгэж байна”<sup>29</sup> гэжээ.

БНСУ-ын ерөнхийлөгчийн сонгууль бүс нутгийн төдийгүй дэлхий дахины анхаарлын төвд байсан юм. Пак Гын Хэ ерөнхийлөгч бол Өмнөд Солонгосын түүхэнд төдийгүй Зүүн Хойд Азийн бүс нутгийн улс орнуудын түүхэнд бичигдэх анхны эмэгтэй ерөнхийлөгч.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн Пак нэр дэвшигчид чин сэтгэлээсээ баяр хүргээд, БНСУ-ын шинэ Засгийн газартай бүх талаар хамтран ажиллахаа илэрхийллээ. Тэрээр Пак нэр дэвшигчийг улс төрийн удирдагчийн хувьд арвин баялаг туршлагатай, олон улсын хэмжээнд нэр хүндтэй хүн гээд зөвхөн Өмнөд Солонгос төдийгүй Зүүн Хойд Азийн анхны эмэгтэй ерөнхийлөгч болсныхоо хувьд эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурь нэр хүндийг өсгөх замаар улс төрийн хөгжилд үнэтэй хувь нэмэр орууллаа<sup>30</sup> гэж дүгнэжээ.

Пак нэр дэвшигчийг сонгуульд ялсны дараа АНУ-ын ерөнхийлөгч Барак Обама түүнд баяр хүргээд АНУ- БНСУ хоёр улсын болоод бүс нутаг, цаашлаад дэлхий дахины тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд БНСУ-ын шинэ Засгийн Газартай хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлж, нягт хамтран ажиллана<sup>31</sup> гэж мэдэгдсэн байна.

ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин сонгуульд ялалт байгуулсанд нь баяр хүргээд хоёр улсын харилцаа амжилттай хөгжиж байгааг дурдаж, цаашид бүхий л салбарт хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.<sup>32</sup> БНХАУ-ын дарга Ху Жинтао хоёр улсын харилцааг улс төр- стратегийн түншлэлийн харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлнэ гэж онцлоод хоёр Солонгосын харилцааг сэргээж, Солонгосын хойгт энхтайван, тогтвортой байдлыг тогтооход дэмжиж туслахаа мэдэгджээ.<sup>33</sup> Түүнчлэн Япон улсын ерөнхий сайд Абэ Шинзо Пак нэр дэвшигчид баяр

28. [http://news.chosun.com/site/data/html\\_dir/2012/12/20/2012122000180.html](http://news.chosun.com/site/data/html_dir/2012/12/20/2012122000180.html)

29. Мөн тэнд.

30. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212200421568809](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212200421568809)

31. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212200540181056](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212200540181056)

32. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212201652374670](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212201652374670)

33. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212210921321496](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212210921321496)

хүргээд түүхийн болон газар нутгийн маргаантай холбоотой асуудлаас болж мухардмал байдалд ороод байгаа хоёр улсын харилцаа нь шинэ засгийн газрын үед хэвийн байдалд орно гэдэгт итгэж байна<sup>34</sup> гэлээ.

Ийнхүү найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлж, Солонгосын хойг болоод Зүүн Хойд Азид энхтайвныг тогтооход хамтран ажиллахаа илэрхийлсэн бүс нутгийн болон дэлхийн улс орнууд Өмнөд Солонгосын шинэ ерөнхийлөгчид өндөр итгэл хүлээлгээд байна.

### Дүгнэлт

БНСУ эмэгтэй ерөнхийлөгчтэй болсон явдал нь тус орны улс төрд гарч буй асар том өөрчлөлт, улс төрийн шинэчлэл юм. Зүүн Хойд Азийн бүс нутгаас төрсөн анхны эмэгтэй ерөнхийлөгч бүс нутгийн болоод олон улсын харилцаанд шинэ өнгө аясыг оруулж, ялангуяа хоёр Солонгосын асуудалд нааштай үр дүн гарах болно гэдэгт АНУ, ОХУ, Япон, Хятад зэрэг бүс нутгийн томоохон гүрнүүд, дэлхий нийт итгэж байна.

Эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалыг сонгосон явдал нь БНСУ-ын олон улсын тавцан дахь нэр хүндийг өсгөж байгаа томоохон үйл явдал билээ. Энэ нь БНСУ-ын нийгмийн сэтгэлгээний өөрчлөлт, шинэчлэл, нийгэм дэх эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь улам бүр нэмэгдэж байгааг илэрхийлж байна. БНСУ-ын нийгэм, ард иргэдийн дунд эмэгтэй ерөнхийлөгчийн засаглалыг хүлээн зөвшөөрөх хандлага хэдийн тавигдсан байсныг дурдах нь зүйн хэрэг билээ.

Солонгосын хойгийн улс төрийн түгшүүртэй байдал нь ард иргэдэд аливаад ул суурьтай ханддаг, алтан дунджыг барьсан, уян хатан бодлого явуулж чадах удирдагчийг сонгохыг зөвлөж байсан юм. БНСУ-ын эдийн засгийн өнөөгийн байдлаас шалтгаалан нийгмийн халамж, эдийн засгийн дэмжлэг туслалцаа авахыг хүссэн дунд давхаргынхны итгэл найдвар, горьдлого нь Пак Гын Хэ дэмжихэд хүргэсэн байна. Мөн түүний улс төрчийн амьдралын туршлага, туулж ирсэн түүхэн замнал, олон улсын нэр хүнд, зарчимч, шударга гэх мэт хувийн зан чанар нь ард түмэнд өндөр итгэл төрүүлсэн болно.

БНСУ-ын иргэд түүнээс нэн тэргүүнд эдийн засгийн оновчтой бодлого явуулж, ард иргэдийн амьдралыг дээшлүүлэхийг хүсэн хүлээж байгаа бол дэлхий дахин Солонгосын хойгийн тогтвортой байдал, ялангуяа Өмнөд болон Умард Солонгосын харилцаа шинэ шатанд ахихад нөлөөлөхүйц алхам хийнэ гэж итгэн хүлээж байна. Пак Гын Хэ ерөнхийлөгчийн ажлын амжилт ололт, алдаа дутагдал нь хоёр Солонгосын харилцаатай шууд хамааралтай байх болно гэж улс төрчид үзэж байна.

(МУИС-ийн ГХСС, ШУА-ын ОУССХ, ХУИС-ийн хамтран зохион байгуулсан “Бүс нутаг судлал: Бүс нутгийн нийгэм соёлын судалгаа” сэдэвт

34. [http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212210005135193](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212210005135193)

### Хавсралт: Холбогдох тоо баримтууд

БНСУ-ын хүн ам (2012 оны 10-р сарын байдлаар)

Нэгж: мянган хүн												
Хүйс	2012 оны 10-р сар											
	ийгн ам	0-9нас	10-19нас	20-29нас	30-39нас	40-49нас	50-59нас	60-69нас	70-79нас	80-89нас	90-99нас	100-аас дээш
Нийт	50,912,3	4,663,6	5,494,2	6,636,9	8,185,6	8,839,7	7,732,9	4,318,3	2,946,2	952,082	130,157	12,540
Эр	25,488,1	2,407,6	3,416,1	3,462,3	4,172,5	4,513,7	3,884,4	2,077,7	1,233,8	286,956	30,107	2,888
Эм	25,424,2	2,256	3,078,1	3,174,6	4,013,1	4,326,1	3,848,5	2,240,6	1,712,3	665,126	100,050	9,652

(Хүснэгт 1)

Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн талаарх судалгаа

Нэгж: мянган хүн/ хувь

	2008	2009	2010	2011	2012
15 аас дээш насны эмэгтэйчүүд	20,273	20,496	20,741	20,976	21,254
Хөдөлмөрийн чадвартай эмэгтэйчүүд	10,139	10,076	10,256	10,416	10,609
Хөдөлмөрийн чадвартай эмэгтэйчүүдийн эзлэх хувь	50.0	49.2	49.4	49.7	49.9
Ажил эрхлэлтийн хувь	53.2	52.2	52.6	53.1	53.5
Ажилгүйдлийн хувь	2.8	3.2	3.4	3.2	3.1

(Хүснэгт 2)<sup>2</sup>

Засаг захиргааны байгууллагад ажиллаж буй эмэгтэй төрийн албан хаагчдын судлагаа

Нэгж: хүн/ хувь

	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Нийт төрийн албан хаагч	256,424	266,176	272,584	275,484	275,231	278,303	279,636	281,035	284,355
Эмэгтэй төрийн албан хаагч	64,683	70,568	75,608	78,855	80,666	82,178	83,282	84,239	87,239
Эмэгтэй төрийн албан хаагчийн эзлэх хувь(%)	25.2	26.5	27.7	28.6	29.3	29.5	29.8	30.0	30.7

(Хүснэгт 3)<sup>3</sup>

Нарийн мэргэжлийн эмэгтэй ажилтнууд болон удирдах ажилтны судалгаа

Нэгж: мянган хүн/ хувь

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Ажил эрхлэгч эмэгтэйчүүд	9,108	9,364	9,526	9,706	9,826	9,874	9,772	9,914	10,091	10,294
Нарийн мэргэжлийн болон удирдах ажилтан	1,541	1,582	1,669	1,823	1,901	1,954	2,016	2,083	2,157	2,223
Эзлэх хувь	16.9	16.9	17.5	18.8	19.3	19.8	20.6	21.0	21.4	21.6

(Хүснэгт 4)<sup>4</sup>

<sup>1</sup> <http://rcps.egov.go.kr>

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Мөн тэнд

<sup>4</sup> <http://rcps.egov.go.kr>

Олон Улсын Парламентын Холбооноос гаргасан эмэгтэй парламентын гишүүдийн судалгаа  
Нэгж: хун/ хувь

	2010			2011			2012		
	байр	Нийт парламентын гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүний эзлэх хувь(%)	байр	Нийт парламентын гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүний эзлэх хувь(%)	байр	Нийт парламентын гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүний эзлэх хувь(%)
Швед	2	349	45.0	4	349	44.7	4	349	44.7
Норвеги	8	169	39.6	11	169	39.6	11	169	39.6
Нидерланд	6	150	40.7	8	150	40.7	14	150	38.7
Австри	28	183	27.9	31	183	27.9	34	183	27.9
ХБНГУ	18	622	32.8	21	620	32.9	24	620	32.9
Англи	52	650	22.0	53	650	22.3	57	650	22.5
АНУ	71	435	16.8	78	434	16.8	77	434	18.0
БНСУ	79	299	14.7	87	299	14.7	87	300	15.7
Япон	95	480	11.3	106	480	10.8	122	480	7.9

(Хүснэгт 5)<sup>5</sup>

### Ашигласан номзүй

1. <주부들이 뽑은 차기 대통령감 박근혜 한나라당 대표> 여성 동아 2005년 8월호  
“Гэрийн эзэгтэй нарын сонгосон дараагийн ерөнхийлөгч Ханнара намын дарга Пак Гын Хэ” Пак Гын Хэтэй хийсэн ярилцлага  
Зүүн Азийн эмэгтэйчүүд сэтгүүлийн 2005 оны дугаар 8.
2. 조운호. <국민 통합과 100% 대한민국, 정말로? 박근혜의 나라와 박근혜의 국민>  
Жу Юн Ху. “Ард түмний эв нэгдэл ба 100% БНСУ, үнэн үү? Пак Гын Хэгийн улс ба Пак Гын Хэгийн ард түмэн.”  
<http://www.mediaus.co.kr/news/articleView.html?idxno=28760>
3. “대통령 당선인에게 바란다. 김형준 교수, 홍연익 박사, 오정근 교수, 현진권 소장” “Шинээр сонгогдсон ерөнхийлөгчөөс хүсэж байна.” Багш эрдэмтэдтэй хийсэн ярилцлага. [http://ytn.co.kr/\\_ln/0101\\_201212201505435301](http://ytn.co.kr/_ln/0101_201212201505435301)
4. <여성대통령 배출한 한국, 세계 여성 리더십의 중심되길 기대>  
한미 여성리더십세미나 연 레슬리 바셋 주한 미국 부대사  
“Эмэгтэй ерөнхийлөгч сонгосон Солонгосыг дэлхийн эмэгтэй манлайлагчдын гол цөм нь болоосой гэж хүснэ. “ АНУ-БНСУ-ын лидер эмэгтэйчүүдийн семинарыг зохион байгуулсан БНСУ-д суугаа АНУ-ын элчийн сайдын хэргийг түр хамаарагч Лесли Баззеттай хийсэн ярилцлага  
<http://monthly.chosun.com/client/news/viw.asp?nNewsNumb=201302100032>
5. 김영희. <박근혜 외교에 바란다>. 김민 Хи “Пак Гын Хэгийн дипломат бодлого” [http://article.joins.com/news/article/article.asp?ctg=20&total\\_id=10452113](http://article.joins.com/news/article/article.asp?ctg=20&total_id=10452113)
6. 매일경제 2012/12/22A28. <매경이 만난 사람 : 한국캘러프조사연구소박희장>.  
“Уулзах хүн: Кореа Галлап судалгааны хүрээлэнгийн Пакзахирал”  
Өдөр тутмын эдийн засаг сонины 2012 -12- 22 өдрийн дугаар. A28 тал.<http://www.mk.co.kr>

#### Байгууллагын албан ёсны цахим хуудас

1. 청와대. <http://www.president.go.kr> БНСУ-ын ерөнхийлөгчийн цахим хуудас
2. 중앙선거관리위원회 [www.nec.gk.kr](http://www.nec.gk.kr) БНСУ-ын Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас

<sup>5</sup> Мөн тэнд

3. 새누리당 <http://www.saenuriparty.kr> Сэнүри намын цахим хуудас. Мөрийн хөтөлбөр
4. 국가통계청 <http://kostat.go.kr/portal/korea/index.action> Улсын статистикийн ерөнхий газар
5. 주민등록인구통계 <http://rcps.egov.go.kr> Иргэний бүртгэлийн цахим хуудас
6. 나라지표 <http://www.index.go.kr/egams/index.jsp> Улсын статистикийн ерөнхий газрын тоон үзүүлэлтийн цахим хуудас
7. UNDP <http://hdr.undp.org/> НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн цахим хуудас  
[http://hdr.undp.org/en/media/HDR\\_20072008\\_GEM.pdf](http://hdr.undp.org/en/media/HDR_20072008_GEM.pdf)
8. World Economic Forum <http://www3.weforum.org> Дэлхийн Эдийн Засгийн Форумын судалгааны тайлангууд  
[http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2009.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2009.pdf)  
[http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2010.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2010.pdf)  
[http://www3.weforum.org/docs/WEF\\_GenderGap\\_Report\\_2011.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GenderGap_Report_2011.pdf)
9. 한국갤럽 [www.gallup.co.kr](http://www.gallup.co.kr) Korea Галлап судалгааны төвийн судалгааны тайлангууд.  
Gallup Report 2012/12/24; 제18대대통령선거, 유권자의후보선택이유는?  
Галлап Кореа судалгааны тайлан. 2012/12/24, 18 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгууль. Нэр дэвшигчийг сонгосон шалтгаан. Хуудас 2.

### *Хэвлэл мэдээллийн эх сурвалжууд*

8. KBS 방송 <http://news.kbs.co.kr> KBS телевизийн цахим хуудас  
[http://news.kbs.co.kr/news/NewsView.do?SEARCH\\_NEWS\\_CODE=2585520](http://news.kbs.co.kr/news/NewsView.do?SEARCH_NEWS_CODE=2585520)
9. MBC 방송 <http://imnews.imbc.com> MBC телевизийн цахим хуудас  
[http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551\\_5780.html](http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551_5780.html)  
[http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551\\_5968.html](http://imnews.imbc.com/replay/nwdesk/article/3211551_5968.html)
10. SBS 방송 <http://news.sbs.co.kr> SBS телевизийн цахим хуудас  
[http://news.sbs.co.kr/section\\_news/news\\_read.jsp?news\\_id=N1001252110](http://news.sbs.co.kr/section_news/news_read.jsp?news_id=N1001252110)
11. YTN 방송 <http://www.ytn.co.kr> YTN телевизийн цахим хуудас  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0101\\_201212200108200554](http://www.ytn.co.kr/_ln/0101_201212200108200554)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201306300849313904\\_001](http://www.ytn.co.kr/_ln/0104_201306300849313904_001)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212200421568809](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212200421568809)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212200540181056](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212200540181056)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212201652374670](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212201652374670)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212210921321496](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212210921321496)  
[http://www.ytn.co.kr/\\_ln/0104\\_201212210005135193](http://www.ytn.co.kr/_ln/0104_201212210005135193)
12. 한국경제 <http://www.hankyung.com> Солонгосын эдийн засаг сонины цахим хуудас  
<http://www.hankyung.com/news/app/newsview.php?aid=2012111101801>
13. 폴리뉴스 <http://www.polinews.co.kr> Полли ньюс мэдээллийн цахим хуудас  
<http://www.polinews.co.kr/news/article.html?no=165453>
14. 아시아투데이 <http://www.asiatoday.co.kr> Өнөөдрийн Ази сонины цахим хуудас  
<http://www.asiatoday.co.kr/news/view.asp?seq=743494>
15. 네이버뉴스 <http://news.naver.com> Навер портал цахим хуудас  
<http://news.naver.com/main/read.nhn?mid=smn&sid1=100&oid=214&aid=0000226175&datetime=2013010121342726175>
16. 조선뉴스 <http://news.chosun.com> Чосоны мэдээ сонины цахим хуудас  
[http://news.chosun.com/site/data/html\\_dir/2012/12/20/2012122000180.html](http://news.chosun.com/site/data/html_dir/2012/12/20/2012122000180.html)